



ГОВЬ ХК-ИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮҮРЭГ АМЛАЛТ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Зорилго

1.1.1 НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17-н зорилго, Даян дэлхийн гэрээний 10-н зарчмын хүрээнд бизнесийн үйл ажиллагааг тогтвортой хөгжүүлэхэд чиглэсэн амлалтыг тодорхойлон сонирхогч талуудад хүргэх, хэрэгжүүлэх, тасралтгүй сайжруулахад оршино.

1.2 Хамрах хүрээ

1.2.1 Энэхүү үүрэг амлалт нь олон нийтэд нээлттэй байх бөгөөд Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчид, төлөөлөн удирдах зөвлөл, нийт ажилтнууд, охин компанийн ажилтнууд, гэрээт компани, ханган нийлүүлэгч болон бусад оролцогч талуудад хамаарна.

1.3 Нэр томъёоны тайлбар

- 1.3.1 **Ногоон худалдан авалт:** Аливаа бүтээгдэхүүнийг худалдаж авахдаа үнэ ба чанарыг харгалзахын зэрэгцээ байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг тооцож сонголт хийхийг;
- 1.3.2 **Ногоон технологи:** Байгаль орчинд эерэг нөлөөтэй буюу байгалийн шавхагдах нөөцүүд болох ус, эрчим хүчинд хэмнэлттэй бөгөөд нүүрс хүчлийн хийн ялгаруулалт хамгийн багатай тоног төхөөрөмж;
- 1.3.3 **Байгальд ээлтэй сав, баглаа, боодол гэдэг нь:**
- 1.3.3.1 Байгальд уусдаг хуванцар уут
 - 1.3.3.2 Дахин ашигласан цаасан хайрцаг
 - 1.3.3.3 Дахин ашиглаж болохуйц материалтай уут сав
- 1.3.4 **Эрх тэгш байдал:** Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахгүй байх байдал;
- 1.3.5 **Тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалт:** Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэж буй бүхий л үйл ажиллагааны зардал;
- 1.3.6 **Бэлчээрийн тогтвортой байдал:** Ургамлын талхлагдлаас урьдчилан сэргийлэх, тасралтгүй сайжруулах цогц арга хэмжээ;
- 1.3.7 **Ургамлын талхлагдал:** Хүн, мал амьтны нөлөөгөөр бэлчээрийн ургамлын үндсэн төрөл, бүрхэвч өөрчлөгдөж чанар чадавх нь муудах үзэгдлийг;
- 1.3.8 **Тогтвортой түүхий ноолуур:** Бэлчээрийн төлөв байдал, малын эрүүл мэнд, мал сүргийн тавлаг байдал, хариуцлагатай малчин, зохистой төлбөр, түүхий эдийн чанар аюулгүй байдал зэрэг шаардлагыг хангасан түүхий ноолуур;
- 1.3.9 **Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг уртасгах:**
- 1.3.9.1 Бүтээгдэхүүний чанарт анхаарах;
 - 1.3.9.2 Хэрэглэгчдээ бүтээгдэхүүн арчилгааны мэдээллээр хангах;

- 1.3.9.3 Худалдан авсны дараах үйлчилгээ болох элэгдсэн бүтээгдэхүүнд нь засвар үйлчилгээг үзүүлэх;
- 1.3.9.4 Нэгэнт өмсөгдөхгүй болсон бүтээгдэхүүнийг нь дахин ашиглалтад оруулах боломжийг олгох;

Хоёр. ҮҮРЭГ АМЛАЛТУУД

2.1 Тогтвортой хөгжлийн удирдлага:

- 2.1.1 Бид цаашид Тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг бизнесийн үйл ажиллагаанд нэгтгэн тасралтгүй хөгжүүлнэ.

2.2 Байгаль орчин:

- 2.2.1 Байгууллагын үйл ажиллагаанаас байгаль орчинд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийг хамгийн бага түвшинд байлгах, мөн сөрөг нөлөөллийг тасралтгүй бууруулах чиглэлээр ажиллана.
- 2.2.2 Үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарсан бохир усны дахин ашиглалтын хувийг тасралтгүй нэмэгдүүлнэ.
- 2.2.3 Ногоон худалдан авалт, ногоон технологийг нэмэгдүүлэх бөгөөд байгальд ээлтэй сав баглаа боодол ашиглана.
- 2.2.4 Мод тарих хөтөлбөр болон хүлэмжийн хийг бууруулах төслүүдийг санаачлан хэрэгжүүлнэ.
- 2.2.5 Хог хаягдлыг дахин боловсруулах хувийг тасралтгүй нэмэгдүүлнэ.

2.3 Нийгэм:

- 2.3.1 Эрүүл, аюулгүй ажлын байраар хангана.
- 2.3.2 Хүний нөөцийн тогтвортой байдлыг ханган, тасралтгүй хөгжүүлнэ.
- 2.3.3 Ажилтан, сонирхогч талуудад хүндэтгэлтэй хандах зарчмаар эрх тэгш байдлыг төгөлдөржүүлнэ.
- 2.3.4 Тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалтыг тасралтгүй өсгөж ажиллана.

2.4 Засаглал:

- 2.4.1 Бизнесийн үнэт зүйл, ёс зүйг хөгжүүлэх замаар байгууллагын соёлыг тасралтгүй дээшлүүлнэ.

2.5 Салбарын үйл ажиллагаа:

- 2.5.1 Бэлчээрийн тогтвортой байдлыг хамгаалахад манлайлан оролцоно.
- 2.5.2 Тогтвортой түүхий эдээр бүтээгдэхүүн үйлдвэрлэн эцсийн хэрэглэгчид хүргэнэ.
- 2.5.3 Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг уртасгана.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ